

2008.02.28

Дугаар 28

“Халык астана дорнод” ХХК-д банк бус
санхүүгийн үйл ажиллагааны тусгай
зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3 дахь заалт, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.1 дэх заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

Нэг.“Казахстаны Халык банк”-ны 100 хувийн хөрөнгө оруулалттай “Халык астана дорнод” ХХК-д банк бус санхүүгийн дараах төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.Үүнд:

- 1.Зээл;
- 2.Факторингийн үйлчилгээ;
- 3.Гадаад валютын арилжаа;
- 4.Төлбөрийн баталгаа гаргах.

Хоёр.Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Халык астана дорнод” ХХК /Маекенов Т.К/-д үүрэг болгосугай.

Гурав.Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Ж.Жадамбаа/, “Халык астана дорнод” ХХК-ийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Банк бус санхүүгийн байгууллагын газар /Х.Бум-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ